



Д.ДОРЖСҮРЭН: МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ НЬ УС ШҮҮ ГЭДГИЙГ БАЙНГА САНУУЛЖ БАЙХ ХЭРЭГТЭЙ



Ус тэр тусмаа цэнгэг усны талаар хурцаар яригдах болжээ. “Дэлхийн банкны 2030 Усны Нөөцийн Бүлгийн Монгол дахь хөтөлбөрийн зохицуулагч Д.Доржсүрэнтэй уулзаж дараах ярилцлагыг хийлээ. Усны бодлого, усны засаглалын талаар юу гэж өгүүлснийг эндээс уншаарай.

Дэлхийн банкны “2030 усны нөөцийн бүлэг”-ээс хэрэгжүүлж байгаа ажил үйлсийн талаар олонтаа сонсож байсан. Энэ хэзээнээс эхэлсэн ямар учиртай төсөл, хөтөлбөр вэ?

-Дэлхий дээр тулгамдаж байгаа асуудлуудыг “Дэлхийн эдийн засгийн форум” дээр ярилцаж хэлэлцдэг л дээ. Олон жилийн өмнө Усны асуудлыг онцлон ярилцсан байдаг. Энэ чигээрээ байвал энэ дэлхий 2030 онд цэнгэг усны хомсдолд орох нь ээ гэдгийг судалж гаргаж ирээд “2030 Усны Нөөцийн Бүлэг”-ийг байгуулсан түүхтэй. Хэдийгээр дэлхийн газар нутгийн ихэнхийг ус эзэлж байгаа ч цэнгэг ус нийт усны ердөө л 2 хувийг эзэлдэг, уух боломжтой нь

0.6 хувь гээд бодохоор энэ үнэхээр тулгамдсан асуудал байгаа биз.

Манай улсад “2030 Усны Нөөцийн Бүлгийн” хөтөлбөр төсөл хэзээнээс эхэлж хэрэгжсэн юм бол? Та энэ хөтөлбөрийн зохицуулагчаар хэзээнээс ажиллав?

-Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2011 онд Дэлхийн эдийн засгийн форумд оролцохдоо “Цэнгэг усны эрсдэлд орох улс орны тоонд манай Монгол улс орчихоод байна” гэдэг асуудлыг анх гаргаж тавьсан юм. Манай Монгол Улс бол Төв Азийн гандуу хуурай бүс нутагт оршдог, эх газрын эрс тэс уур амьсгалтай орон. Нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувийг ус чийгийн хомсдолтой говь, цөл,

тал хээрийн бүс эзэлдэг бөгөөд энэ бүс нутагтаа гадаргын усны эх үүсвэргүй гэдгийг бүгд мэднэ. Уур амьсгалын өөрчлөлтөд дэлхийн дундажаас бараг 3 дахин илүү өртдөг, усны нөөц ялангуяа цэнгэг усны нөөц нь хурдацтайгаар хомсдож байна гэдгийг онцлон хэлж ярьж, таниулан Монгол улсад туслахыг хүссэн байдаг юм. Ингээд 2 жил судалсны дараа 2013 онд энэ хөтөлбөр манай улсад хэрэгжихээр болсон юм. Тэр цагаас хойш энэ алба ажлыг хашиж байна.

Энэ төсөл хөтөлбөр хэрэгжиж эхлээд долоо найман ч жил өнгөрчээ. Хөтөлбөрийн гол агуулга нь юу юунд чиглэгдэж байна вэ?

-Бид байгалиа хамгаална гэдгийг онгон дагшин байгальдаа хүн ойртуулахгүй, хүргэхгүй байх гэж ойлгож, тийм бодлогыг барьж ирсэн байдаг. Гэтэл Дэлхийн эдийн засгийн форум бол эдийн засгийн өсөлт, хүний амьжиргааны өсөлт нь Байгаль орчны хамгаалалтайгаа зэрэгцээд явж болдог гэдгийг тодорхойлж өгсөн байдаг. Энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулахад онцгой нөлөөлж байдаг юм байна. Тухайн асуудлын үндсэн мөн чанарыг танин мэдэх, тулгамдаж байгаа асуудлыг тогтоох, түүнийг даван туулах, гацаанаас гарах арга замыг тогтоодог юм байна. Энэ нь байгаль орчин, нийгмийн тодорхой асуудлыг шийдэж чадах уу гэдгийг онцгойлон хардаг. Тухайн ажил арга хэмжээний байгаль орчны



сөрөг нөлөөг бууруулж болох уу гэдгийг бас гол болгоно. Энэ бүгд тогтвортой хөгжлийн үндэс болж байдаг.

Дэлхийн эдийн засгийн форум асуудлыг саяын таны ярьсан өнцгөөс хардаг гэж ойлгож болох уу. Асуудлыг их олон талаас нь ярьдаг, хардаг байх нь. Манай монголчууд ч “Бүгдээрээ хэлэлцвал буруугүй...” гэлцдэг л дээ.

-Тийм ээ. Аливаа асуудлыг олон талаас нь харж, судалгаатай, үндэслэлтэй хийдэг нь манай гол үндсэн зарчим. Төр засгийн удирдлага, компанийн эзэд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн төлөөллүүд яг дээрх өнцгөөс хардаг, ярьдаг, улмаар шийдэлд хүрдэг. Тал талаас нь ярьж шийддэг болохоор чухал үр дүнд хүрдэг. Ийм тохиолдолд харилцан ойлголцол, түншлэл бий болдог л доо. Хамгийн ойрхоны жишээ жорлон байна. Энэ асуудлыг ярьсаар байгаад технологийн шийдлийг эрдэмтэд нь гаргаад ирдэг. Компаниуд үүнийг нь бизнес болгож, үйлдвэрлэлд оруулаад ирдэг. Гэтэл Иргэний нийгмийн байгууллагууд эсэргүүцдэг. “Ийм өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг хэн авах юм бэ, ард олон ийм үнийг дийлэхгүй” гэхчилэн эсэргүүцдэг. Энэ асуудлыг хамгийн сайнаар шийдсэн нь Швейцарь байна. “Танайх тэр асуудлаа яаж шийдсэн билээ. Одоо Монгол Улсад тусла, зөвлө, туршлагаа хуваалцаач” гэж

Дэлхийн эдийн засгийн форумаас зөвлөдөг. Эндээс гайхалтай сайхан санаанууд ажил хэрэг болж байдаг л даа. Ийм замаар манай хөтөлбөрийн үйл ажиллагаа явагддаг.

Танай “2030 Усны Нөөцийн бүлэг” устай холбоотой ямар томоохон ажил үйлсэд оролцов? Манай улсын усны бодлого ер нь ямархан түвшинд яваа юм бол оо?

-Устай холбоогүй нэг ч салбар, нэг ч албан байгууллага, айл өрх, хувь хүн гэж байхгүй шүү дээ. Бүгд л усыг хэрэглэж, ашиглаж байгаа. Бид хамгийн түрүүнд усны талаар баримталж байгаа Монгол Улсын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж нь Олон улсын шинжээчдийн дүгнэлтээр ямар байгаа юмбэ гэдгийг судалж, гаргуулсан. Энэ дүгнэлтээр Монгол Улсын усны тухай хууль тогтоомжууд нь ардчилал, зах зээлийн харилцаандаа тохирч байна гэж үзсэн. Гэхдээ маш том доголдол байна. Тэр нь хэрэгжилт. Сайн хуультай ч хэрэгжилт нь нойль байна гэдгийг гаргаад ирсэн.

Хичнээн сайн хууль байгаад ч хэрэгжихгүй бол ямар нэмэр байх билээ дээ. За энийг сайжруулах ямар арга зам байна гэж үзсэн бэ?

-“Хуулиа судалдаггүй, амьдралд биелэл болгодоггүй улс байна” гэж улайтал хэлсэн дээ. Иргэд, аж ахуйн нэгж ер хаа газар

хариуцлагын тогтолцоо гэж алга. Яг энэ байдлаараа явах юм бол 2030 он гэхэд Монгол Улс усны хомсдолд орох эрсдэл байна. Усны бодлого нь Эдийн засгийн өсөлтөө дэмжихүйц байж чадахгүй байна. Зах зээлийнхээ эдийн засгийн үндсэн механизмуудыг дутуу суулгажээ гэж дээрх шинжилгээ 2014 онд дүгнэсэн л дээ. Эндээс бид дүгнэлт хийгээд хамгийн түрүүнд зах зээлийн эдийн засгийн харилцаанд бүрэн шилжүүлэх, цэнгэг усныхаа нөөцийг хамгаалах ажилд орсон. Эдийн засгийн хөшүүргийг нь суулгаж өгье гэдэг үүднээс Ус бохирдуулсаны төлбөрийг ногдуулахаар болов. Мөн усны нөөцийн экологи эдийн засгийн үнэлгээг өөрчлөх ажилд орлоо. Өмнөд бүс болон Улаанбаатарын бүсэд “Гидро эконоимкийн анализ”-ийг мөн хийсэн.

Уул уурхайн үйлдвэрлэл түлхүү явагдаж байгаа, хүн амын төвлөрөл хамгийн ихтэй хоёр газрыг сонгож анализ хийжээ. Энэ судалгаагаар ямар дүгнэлт гарч байх юм?

-Тийм ээ, 2040 онд үүсэх усны эрэлтүүд нь нийлүүлэлтээсээ давах тооцоо гараад ирсэн. Тэрийг яаж шийдэж болох вэ гэдэг хувилбаруудыг ч тооцсон. Ингээд Улаанбаатарын төв цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглая гэсэн зөвлөмж өгсөн. Энэ ажлыг өнөөдөр “Мянганы сорилтын сан”-гаас санхүүжүүлж шийдэхээр одоо төслөө хэрэгжүүлээд явж байна. Дэлхийд нэр хүндэтэй байгууллагаас хийсэн тооцоо, судалгаанд хэн ч эргэлздэггүй, тэнд үнэхээр нарийн нягт судалж тооцдог тул санхүүжүүлэх боломж нь нээгддэг юм байна.

Өмнөд бүсийн том том уурхайд ус ашиглалт мэдээж асар хурдацтай нэмэгдсээр байгаа нь ойлгомжтой. Энд ямар гарц, шийдлүүд гараа бол?

-Энэ бүс нутагт 2030 оноос эхлээд 2040 он гэхэд усны том

том эрэлт бий болох юм. Эхлээд тэнд байгаа усыг хамгийн зөв зохистой ашиглах нь чухал. Уул уурхайн үйлдвэрлэлээс үүсэж байгаа тоосжилтыг дарахын тулд ус их шаардлагатай байгаа. Үүнд ус биш хуурай химийн бодис ашиглах зэрэг янз бүрийн хувилбарууд гарсан. Мөн Орхон, Хэрлэнгээс ус татах гэхчилэн бүхий л хувилбаруудыг шинжлээд эрэмбэлээд гаргачихсан байгаа. Тэгэхгүй бол “Миний төсөл хамгийн сайн нь” гээд хэрэлдээд байдаг. Нэгд, хоёрт, гурав, дөрөвт ийм хувилбарууд байна гээд гаргачаар төрөөс энэ талаар шийдвэр гаргахад, хувийн хэвшил, санхүүжүүлэгч талууд хөрөнгөө оруулах шийдэл гаргахад, олон нийт, иргэний нийгмийн эргэлзээ, түгшүүр багасдаг. Хамгийн гайхалтай нь энэ. Тэгэхгүй манайхан хийхээсээ өмнө хэрэлдэж маргалдаад хичнээн их цаг хугацаа алддаг билээ. “Өргөн нарийн цариг...” гээд өчнөөн жил хий хоосон маргасныг санаж байгаа байх.

Дэлхийн эдийн засгийн форум бол судалгаан дээр, шинжлэх ухаан дээр түшиглэсэн том том төслүүдийг авч хэлэлцдэг, хөрөнгө санхүүг гаргадаг нь мэдээж. Зах зээлийн нийгэмд зохирсон байгаль орчноо дээдэлсэн үйл ажиллагааг их чухалчилдаг нь анзаарагддаг л даа?

-Тийм ээ. Манайх яг тэдэн шиг эдийн засагтаа, байгаль орчиндоо ийм ийм том төсөл хэрэгжүүлнэ гээд анхнаасаа эрэмбэлээд явсан бол байдал их өөр байх байлаа. Аливаа зүйлийг хийхэд эхлээд шинжлэх ухааны үндэслэлээ гаргахаасаа л эхлэх нь зүйтэй. Эндээс хамгийн дөт, үр ашигтай хувилбараа тогтоогоод энэ дээрээ үндэслээд дөрвөн тал ярилцаад санал нэгдчих хэрэгтэй юм.

Дөрвөн тал гэж?

-Төр засаг бодлогоо зөв сайхнаар тодорхойлчих. Түүн дээр нь үндэслээд компаниуд хөрөнгө оруулна. Товчоор хэлбэл

Төр-Хувийн хэвшил-Иргэний нийгэм гурав хоорондоо харилцан ойлголцох, үүнд нь мэргэжлийн эрдэмтэд, судлаачдын бодит шинжилгээ, дүгнэлт, зөвлөмж байх хэрэгтэй юм. Зах зээлийн эдийн засгаа хөгжүүлбэ гэвэл хүссэн хүсээгүй энэ гурвын сонирхол тулгардаг.

Манай усны салбар энэ асуудлыг Талуудын оролцооны зөвлөлөөр маш сайхан шийдэж өгсөн байгаа. Дээрх 3 талын төлөөллийг оролцуулаад Сав газар бүхэн Талуудын Оролцооны Зөвлөлтэй болсон юм. Хэрлэн гол тунгалаг сайхнаараа тасралтгүй урсаж байвал энэ 3 талд бүгдэд нь хэрэгтэй. Энийг шийдэхийн тулд дээрх талууд толгойгүй дугуй ширээнд сууж, тулгамдсан асуудлын хамгийн зөв гарц, шийдлийн хувилбарыг эрдэмтэд, судлаачдын дүгнэлт, зөвлөмжөөс олж харж бусад талуудтайгаа харилцан саналаа нэгтгэх юм.

“Усны засаглал” гэж ярьж бичдэг болжээ. Энэ засаглал хэр бэхжиж байна гэж боддог вэ?

-Судалгаан дээр, шинжлэх ухаан дээр түшиглэсэн зүйлээ гаргаад ирэхээр хэнтэй ч хэл амаа ололцож болдог. Ингэснээр харилцан ойлголцлын механизм бий болдог.

Харилцан ойлголцлоос түншлэл улмаар түүнээс хамтын ажиллагаа бий болдог. Ус бол стратегийн үнэт баялаг. Нийтийн эрх ашигт хамаатай амин чухал эрдэнэ юм. Энэ үнэт зүйл дээр тулгарч байгаа асуудал дээр төвлөрч бид ажиллах ёстой. Өнөөдөр хэл үгээ ололцдог механизмтай боллоо. Улмаар түншилж байна, хамтарч байна. Шийдэлд хүрч байна. Энийг бид усны салбарт оруулж ирж нутагшууллаа. Өнөөдөр Усны талуудын оролцоонд 1000 гаруй хүн оролцож байна.

-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар түүний харьяа, орон нутаг аймгуудад үйл ажиллагаа явуулдаг Сав газрын захиргаан дээр устай холбоотой бүхий л асуудлууд яригдаж, шийдэгдэж байна уу?

-Тийм ээ, Сав газрын захиргаад бол төрийн үйлчилгээг орон нутагт үзүүлдэг мэргэжлийн байгууллага. Тэд усны талаарх төрийн бодлого, мэргэжлийн үйлчилгээг орон нутгийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэнэ. Нөгөө талаас таны ус уух эрхийг өнөөдөр танаас асуухгүйгээр хөндөж шийдэхгүй улмаар та түүнийг шийдвэрлэхэд оролцох боломжтой болсон. Энэ бол ардчилалын гол зүйл шүүдээ.





Ийм зүйлийг бид усны салбарт хийж чадсан. Шийдвэрийг Талуудын оролцоотой гаргана. Оролцоот засаглал бол ардчилал юм.

Ус бохирдуулсан бол төлбөрийг нь тухайн этгээдээр төлүүлдэг, гаргуулдаг болж байна. Энэ нь усандаа ариг гамтай, хямгатай байх нэг сайхан эхлэл болж байх шиг ээ?

-Харин тийм, 2012 онд баглагдаад долоон жил хэрэгжээгүй байсан хуулийг амилуулсаан. Энэ бол Ус бохирдуулсны төлбөрийн хууль. Эдийн засгийн аргаар хамгаална гэсэн үг. Ус бохирдуулаад байгаа нөхөрт нөхөн төлбөр тавьчихаж байгаа юм. Энэ хуулийг хэрэгжүүлэхдээ бид доод шатыг нь доошлуулаад, дээд шатыг нь дээшлүүлэн хэрэгжүүлээд эхэлсэн. Ингэснээр урсаж байгаа Орхон, Туул руугаа бохироо асгаад байхгүй болж байна. Тэгж асгаж гэмээнэ тухайн аж ахуйн нэгж дампуурахаас өөр замгүй болтол нөхөн төлбөр тавигдана. Ингэж бид зах зээлийн эдийн засгийн хөшүүрэг хийгээд өгсөн.

Цэвэрлэх байгууламж барих тоног төхөөрөмжүүдийг гаалийн татвараас чөлөөлөх гэх мэтээр эдийн засгийн механизмуудыг суулгаад өгчихлөө.

Усны бодлого тодорхой, цэгцтэй сайхан болсоор л байгаа юм байна. “Ус цаг шиг элбэг юм, хар ус шиг үнэгүй юм...” гэж ярьж хөөрөх нь ч багасч, усны үнэ цэнийг хаана хаанаа сайхан ухааж тусгаж авч байх шиг байна аа?

-Тийм шүү. Түүнээс гадна бид бас нэгэн чухал зүйлийг хийсэн юм. Энэ нь үйлдвэрүүд арьс шир угаалаа, тэрнээс нь хаягдал ус гарлаа. Тэрийгээ дахин боловсруулаад ашиглавал төлбөрөөс чөлөөлнө гээд заачихлаа. Улмаар хаягдал усыг дахин ашиглах стандартыг бий болгоод өгсөн. Энэ бас маш чухал суурь асуудлууд нь шийдэгдсэн гэсэн үг юм..

Өмнөд бүсэд уул уурхайнууд ажиллаад ирэхээр газрын гүний ус нь шавхагдаад говь нутаг тэр чигээрээ сөнөсөн ертөнц болно гэж сүржигнэж байсан үеийг бас санаж байна. Энэ тал дээр ямар судалгаа, дүгнэлтүүд байдаг юм бэ?

-Хэдэн уурхай ажиллаад ирэхээр үнэхээр говийн тэр усыг ховх сороод дуусгачих магадлалтай юу?

Энэ үнэн үү? Худлаа юм уу гэдгийг хэмжих, хянах ёстой. Усны салбарынхан зүтгэж байж газрын доорх усны мониторингийн цэгүүдийг бий болгосон. Өнөөдөр

Монгол улсад 280 ийм цэг байна. Тэр цэг дээрээс хоногт 5-6 удаа хэмжилт хийж, мэдээллээ автоматаар өгч байна. Энэ бүхнийг бид Энэтхэгийн талтай хамтарч хиймэл оюун ухаанаар дээрх өгөгдлийг шинжилж боловсруулах боломжийг бүрдүүллээ. Хүний биед зүрхний бичлэгийг хэд хоногийн турш хийж түүнийгээ үзэж судлаад оношийг нь тогтоодогтой адил тэр цэгүүдээсээ байнга мэдээлэл авч шинжилж байна. Ингэж хянаж хэмжиж чадахгүй бол менежмент хийж чадахгүй. Энэ их өгөгдөлд хиймэл оюун ухаанаар бүхий л дүгнэлтийг хийх боломж нээгдэж байна. Монгол Улсын саалийн үнээ болсон уурхай үйлдвэрүүдийг “Ус сорогч шулам” гэж хэлж чадахгүй. Үнэхээр ховх сороод байгаа бол тэрийг нь бас гаргаад ирэх юм л даа. Оюутолгойн ордыг 2003 онд ашиглаж эхлэх үед Хэрлэн, Сэлэнгэ гол хүртэл газрын гаваар сорогдон алга болно гэж бичиж ярьдаг хүмүүс байсан. Өнөөдөр эдгээр гол ус урсдагараа урсаж л байгаа биз дээ.

Усны салбарт ингэж мэдээллийн технологийн дэвшилтэт арга хэрэгсэл сайн нэвтэрч байгаад олзуурхахаас аргагүй.

Дэлхийн эдийн засгийн форумаас хэрэгжүүлсэн “2030 Усны Нөөцийн Бүлэг”-ийн хөтөлбөр Монголд олон олон шинэ зүйлийг авч иржээ. Энэ том хөтөлбөр, энэ нөр их ажлын зохицуулагчаар ажиллаж байгаа Танд талархах учиртай юм байна.

-Үнэхээр даацтай томоохон ажлууд хийгдээд зарим нь биелэлээ олоод явж байгаад энэ салбарын мэргэжилтний хувиар баяртай л байдаг юм. Одоо манай усны салбар “Дижитал шилжилт”-д ороход бэлэн болчихоод байна. Энэ хөтөлбөр бол Монгол Улсын усны салбарын хөгжлийг эдийн засгийн хөгжилтэй нийүүүлэн урагшлуулсан, дижитал шилжилтэд бэлдсэн чухал ач холбогдолтой үйл ажиллагаа байлаа. 2020 онд Усны газар

шинээр бий болж, усны засаглал бэхжиж хөгжиж байна. Одоо дараагийн 10 жилд баримтлах усны бодлого, стратегийг боловсруулах ажил хийгдэж байгаа зэрэг чухал л он жилүүд өнгөрч байна даа.

Усны менежментийг олон алхмаар урагшлуулсан энэ хөтөлбөрийн үр дүнгийн талаар та цухас дурдлаа. Хөтөлбөрийн үр дүнг та маш товчхоноор базаад хэлнэ үү?

-Энэ хөтөлбөр хэрэгжснээр Монгол улс 2030 он гэхэд цэнгэг усны хомсдолд орохгүй улс болсон. 2030 онд усны бодлого нь тодорхой бас оновчтой, ус нь эдийн засгийн хөгжил, өсөлтийн хурдасгуур болдог, цэнгэг ус, байгалиа дээдлэн хамгаалдаг хөгжингүй улс орон болно гэдэгт итгэл төгс байна.

Одоо энэ хөтөлбөр хэдэн он хүртэл үргэлжлэн хэрэгжих вэ? Хугацааг сунгах болов уу?

-Манай энэ хөтөлбөр 2013-2018 оны хооронд хэрэгжээд эхний шат нь дууссан. Улмаар хөтөлбөрийг 2023 он хүртэл сунгасан. Түүнээс цааш яахыг сайн мэдэхгүй байна.

Усны салбарын ирээдүйг та өөдрөг сайхнаар харж байна уу?

-Тийм ээ, улс орны эдийн засгийн хурдасгуур болсон дэвшилтэт салбар болно. Монгол Улс усан дээр бодлогоо хэнээс асуулгүй тодорхойлж, зохицуулалтаа хийгээд явах, үнэ тарифаа өөрчлөн хэрэгжүүлэх эрхээ авч үлдсэн. Одоо жилд 47 тэрбум төгрөгийг уснаасаа олж чадаж байна.

Энэ бол том дэвшил биш гэж үү? Усандаа эзэн болж чадаж байна гэдэг цусандаа эзэн болж байгаатай агаар нэг юм. Монгол Улсын Засгийн газрын гарт нь Усны менежмент байж байна. Монголын ард түмний үнэт зүйл нь энэ ус шүү.

Та бол өөрөө уул усандаа ойрхон өсөж торнисон хүн байх. “Хэт нутаг хаана вэ, хэрэг зориг юунд вэ” асуудаг нь нүүдэлчин монголчуудын мэндчилгээ байсан. Та хаана төрж өссөн бэ?

-Би Завхан аймгийн Их-Уул сумын хүн. Жирийн малчин айлын хүүхэд. Малчны хүүхэд өвс ногоо, ус ургамлын дунд л өсөж хүмүүждэг. Ам болгоноос нь булаг шанд урссан тийм сайхан хангайд хүн болжээ. Дуртай газраа буугаад дураараа цэвэр сайхан булгийн ус залгилж өссөнсөн. Арван найм хүртлээ малчны амьдрал дунд явсан. Малчны амьдрал бол тэр чигээрээ байгаль дунд өрнөдөг. Энэ сайхан байгалаа хэвээр авч үлдэх юмсан, түүний төлөө өчүүхэн ч гэсэн юм хийхсэн гэж боддог доо.

Усны салбартай хэзээ анх холбогдож байв? Усны мэргэжил эзэмжиж, улс орондоо хүчээ өгч эхлэв үү?

-Би 1990 оноос л ус эрдэнэтэй холбогдсон хүн дээ. Одоогийн Шинжлэх ухаан технологийн их сургуулийг газар доорх усны хайгуулын инженер мэргэжлээр төгссөн. Гидрогеологич мэргэжил эзэмшээд л устай нөхөрлөж, шадарласан гэж болно. 2010 онд эрдэмтэн судлаачдын хамтаар

“Ус” хөтөлбөрийг боловсруулж, усны бодлогоо тодорхойлон УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж байлаа.

Усаа хамгаална гэдэг бол цусаа хамгаалж байгаатай адил ариун сайхан үйлс гэж та түрүүнд дурдсан. Усны эх үүсвэр газар болсон уулсыг бас тусгай хамгаалалтанд нэлээд авах шиг боллоо. Энэ тал дээр тоо баримт хэлнэ үү?

-Ус бүрэлдэх эх, усны эх ундарга нь болсон газар нутгийг улсын тусгай хамгаалтанд авсаар байгаа. Өнөөдөр тэр л газар нутгийнхаа 60 гаруй хувийг хамгаалалтанд авчихаад байна. Энэ эх үүсвэрүүдээ тусгай хамгаалалтанд авчих юм бол ирээдүй хойчийн маань ус уух заяа хэвээрээ л байна гэж итгэдэг.

“Ногоон хөгжил” гэж их ярьдаг, олон нийт ч мөн энэ хандлага руу бас боломжийн орж байна уу даа гэмээр харагддаг. Энэ бодлогыг боловсруулахад та бас оролцож явав уу?

-Манай газар нутгийн 70 гаруй хувь нь говь цөлөрхөг хээр, тал хээр. Усны байнгын хасах баланстай. Энэ байгаа нөхцөлдөө тултал менежмент хийх хэрэгтэй юм. Ийм учраас бүх үйлдвэрлэл ногоон байх учиртай. Энэ нь байгаа юмандаа маш ариг гамтай хандах улмаар дахин ашигладаг зарчмаар хэрэгжих болов уу. Үүнд усыг цэвэрлэж эргүүлэн ашиглах ч орно. Энэ л Монгол Улсын ногоон хөгжлийн нэг гол шалгуур юмдаа.

Ярилцсан А.Лхагва



БҮСЧИЛСЭН СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД БОЛЛОО

“УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД” СЭДЭВТ САВ ГАЗРЫН ЗАХИРГААДЫН БҮСЧИЛСЭН СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ГУРВАН Ч ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Баруун бүсийн сав газрын захиргаадын бүсчилсэн сургалтыг “Усны тухай болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд” сэдвээр 2030 Усны нөөцийн бүлгийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр Усны газар нь Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаатай хамтран Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын “Улаагчны хар нуурын аялал жуулчлалын бааз”-д 2021 оны 09 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулав.



Бүсийн сургалтад Харнуур-Ховд, Хүйсийн говь-Цэцэг нуур, Хяргас нуур-Завхан, Идэр, Увс нуур-Тэс, Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаадын

нийт 36 албан хаагчид хамрагдлаа. Завхан аймгийн Онцгой комиссын сургалт зохион байгуулах зөвшөөрөл, цар тахлын үеийн заавар зөвлөмжийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг нарийн чанд сахин мөрдүүлж, сургалтад оролцохоор ирсэн автомашин бүрээс нэг зорчигчийг сонгон “Ковид 19”-ын вирус илрүүлэх түргэвчилсэн тест авч нэвтрүүлсэн бөгөөд сургалтын үеэр танхимын агаар сэлгэлтийг 30 минут тутамд хийж, хурлын зааланд орсон хүн бүрийн биеийн халууныг үзэж тэмдэглэл хөтлөн, хяналт тавьж ажиллав.

“Усны тухай хууль, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд” сэдэвт Баруун бүсийн сав газрын захиргаадын сургалтад илтгэгчид доорх сэдвээр илтгэл тавьж оролцов. Үүнд:

- “Төрөөс усны талаар баримтлах бодлого” сэдвээр Усны газрын дарга Ш.Мягмар;
- 2030 Усны нөөцийн бүлгээс Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийг боловсронгуй

болгох дэмжлэгээс” сэдвээр 2030 Усны нөөцийн бүлгийн зохицуулагч Д.Доржсүрэн;

- “Салбарын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах нь” сэдвээр Усны газрын Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга И.Наранчимэг;
- “Усны тухай хуулийн хэрэгжилт, ус ашиглалт, анхаарах асуудал” сэдвээр Усны газрын Ус ашиглалтын хэлтсийн дарга Х.Шүрэнцэцэг;
- “Ус бохирдуулсны төлбөрийн талаарх олон улсын туршлагауд” сэдвээр 2030 Усны нөөцийн бүлгийн зөвлөх Б.Одбаяр;
- “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт, дагалдан гарсан дүрэм, журмын танилцуулга”, “Ус бохирдуулсны төлбөр тооцох, төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх” нөхцөл сэдвээр Усны газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн Л. Хишигдулам нар танилцуулга хийв.



ТӨВИЙН БҮСИЙН СУРГАЛТ АРВАЙХЭЭРТ БОЛЛОО



Төвийн бүсийн сав газрын захиргаадын бүсчилсэн сургалтыг “Усны тухай болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд” сэдвээр

2030 Усны нөөцийн бүлгийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр Усны газар нь Онги-Таац голын сав газрын захиргаатай хамтран Өвөрхангай аймгийн Арвайхээр

сумын “Өгөөмөр-Өргөө аялал жуулчлалын бааз”-д 2021 оны 09 дүгээр сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулав.

Бүсийн сургалтад Сэлэнгэ, Бөөнцагаан-Орог нуур, Дэлгэрмөрөн-Шишхэд, Хануй, Онги-Таац, Хөвсгөл нуур-Эг, Алтайн өвөр говь, Орхон-Чулуут голын сав газрын захиргаадын нийт 36 албан хаагчдыг хамруулсан. “Усны тухай хууль, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд” сэдэвт Төвийн бүсийн сав газрын захиргаадын сургалтад илтгэгчид дээрх сэдвээр илтгэл тавьж оролцов.

ЗҮҮН БҮСИЙН СУРГАЛТ ХЭНТИЙ АЙМАГТ БОЛОВ

Зүүн бүсийн сав газрын захиргаадын бүсчилсэн сургалтыг Усны газар нь Хэрлэн голын сав газрын захиргаатай хамтран Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын “Гэгээнтний Өргөө аялал жуулчлалын бааз”-д 2021 оны 09 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулав.

Бүсийн сургалтад Хэрлэн, Хараа-Ерөө, Буйрнуур-Мэнэнгийн

тал, Туул, Галба-Өөш, Долоодын говь, Умард говийн гүвээт-Халхын дундад тал, Онон-Улз голын сав газрын захиргаадын нийт 36 албан хаагчдыг хамруулсан. “Усны тухай хууль, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд” сэдэвт Зүүн бүсийн сав газрын захиргаадын сургалтад илтгэгчид дээрх сэдвээр илтгэл тавьж оролцов.


Энэхүү бүсчилсэн сургалтууд нь Сав газрын захиргаатайгаа биечлэн уулзаж, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдсан асуудлуудыг шийдэж, цаашдынх нь ажил үйлсийг чиглүүлж өгсөн үр дүнтэй чухал ажил боллоо гэж Усны газрын Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга И.Наранчимэг ярилаа.



ОНГИ - ТААЦ ГОЛЫН САВ ГАЗАР

Нутаг дэвсгэр:

Онги голын сав газар нь Монгол орны засаг захиргааны нэгжийн Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгийн 29 сумын нутаг дэвсгэрийн 39201.5 хавтгай дөрвөлжин км талбайг эзлэн орших бөгөөд нийт талбайн 55 орчим хувь нь Өмнөговь, 32 гаруй хувь нь Өвөрхангай, 13.5 хувь Дундговь аймгийн нутагт багтана. Онги голын сав газарт Өвөрхангай аймгийн Арвайхээр, Тарагт, Баянгол, Зүүнбаян-Улаан, Уянга, Богд, Төгрөг, Өмнөговь аймгийн Даланзадгад, Булган, Мандал-Овоо, Хонгор, Цогт-Овоо, Баяндалай, Дундговь аймгийн Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдын нутгаас хамрагдана.



Онги гол

Онги гол нь Хангай нурууны өврөөс эх авч Хангай, хээр, говийн гурван бүсийг дамжин 435 км урсахдаа 52920 км² талбайгаас усжин, Улаан нуурт цутгана. Баруун ба Зүүн Улаан /Өвөр-Улаан/ голын бэлчрээс эхлэн Онги хэмээн нэрлэгдэнэ. Баруун Улаан гол 2870 м өндөрт орших Ногоон нуураас эх авах ба Зүүн Улаан голоос ус ихтэй учир Онги голын эх гэж үзнэ. Онги голын эхэнд Хятруун, Битүүт, Бараанчулуут,

Цагаанчулуут Шуранга, Бөөрөлжүүт, Асралт, Асгат, Тээл, Өвт, Ар-Өлт зэрэг голууд Онгийн голд тус тус цутгана.

ТААЦ ГОЛЫН САВ ГАЗАР

Нутаг дэвсгэр:

Таац голын сав газар нь Өвөрхангай аймгийн 9, Баянхонгор аймгийн 2, Өмнөговь аймгийн 1 сумын нутаг дэвсгэрийг хамран нийтдээ 25,425 км² талбайг эзэлдэг. Үүнээс Өвөрхангай аймгийн 24,537,6 км², Баянхонгор аймгийн 874,5 км², Өмнөговь аймгийн 13 км² газар хамрагдана.

Таац гол:

Таацын гол нь Уянга сумын Жаргалант багийн Хангай нуруунаас эх авч Нарийнтээл сумын нутгийг дамжин 200 км урсч Баруунбаян-Улаан сумын нутаг дахь Таацын цагаан нуурт цутгадаг. Таац голын ай сав газарт “Ар агуйтын гол” “Цараа гол” “Бүдүүний гол” “Тээлийн гол” “Харзтайн гол” “Арцын гол” “Шаргын гол” “Бөмбөхийн гол” гэх мэт жижиг голууд багтдаг.



ОНГИ-ТААЦ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А-233 дугаар тушаалаар “Онги голын сав газрын захиргаа”, Байгаль орчин,

ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 30 өдрийн А/152 дугаар тушаалаар “Таац голын сав газрын захиргаа” тус тус байгуулагдсан.

2015 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Онги голын сав газрын захиргаа, Таац голын сав газрын захиргаад нь нэгдэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 02 сарын 26 өдрийн “Онги-Таац голын сав газрын захиргааны бүтэц, орон тоо, дүрэм батлах тухай” А/103 дугаар тушаалаар “Онги-Таац голын сав газрын захиргаа” болон шинэ бүтэц зохион байгуултад орж, нийт 9 орон тооны ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Захиргааны бүтэц, зохион байгуулалт:

- Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, даргын албан үүргийг түр орон гүйцэтгэгч С.Дуламрагчаа
- Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөлт, сургалт, олон нийт, хариуцсан мэргэжилтэн Ш.Дуламжаргал
- Газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн
- Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Дамдинсүрэн
- Газарзүйн мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн Ц.Цэвээнсүрэн
- Усны чанар, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Я.Лхам
- Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Гантулга
- Нягтлан бодогч Б.Ганчимэг
- Жолооч Д.Мөнххуяг нар тус тус ажиллаж байна.



Хийж хэрэгжүүлсэн ажлуудаас товч дурьдвал:

1. Онги-Таац голын сав газрын захиргаанаас 2018 онд Монгол улсад Усны салбар үүсч хөгжсөний 80 жилийн хүрээнд ойн нэрэмжит усан оргилуур, хөшөө бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн бүтээн байгуулалтын ажлыг 560м² талбайд хийж гүйцэтгэв. Ойн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан газрын 342м² талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг хийж, 180 гаруй мод тарин ногоон байгууламжийг нэмэгдүүллээ. Мөн ойн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнгийн 9м² талбайд усан оргилуур, хөшөө босгож, 9м² талбайд явган хүний зам тавьж, сандал, гэрэлтүүлэг байрлуулж, нийт 21 сая төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэв.

2. БОАЖЯ, Усны газар, Экологийн цагдаагийн албанаас хамтран зарласан “Цэнхэр алт-Усаа хайрлая!” аяныг Өвөрхангай аймагт амжилттай зохион байгуулж, Монгол улсын 21 сав газрын захиргаанаас 1-р байрт шалгарсан.

3. Онги-Таац голын сав газрын талуудын оролцооны зөвлөлийг 2018 онд байгуулсан ба зөвлөлийн даргаар Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдорж сонгогдож, 4 аймгийн 20 сумын

төлөөлөл бүрдсэн, нийт 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

4. Онги-Таац голын сав газрын захиргаань 2015 оноос хойш ашиглах боломжит усны нөөцөд тулгуурлан жил бүр аймгийн төсөвт ус ашиглуулсны төлбөрийг төвлөрүүлдэг. Энэ хугацаанд жил бүр төвлөрүүлэх татварын орлогыг давуулан биелүүлж нийт 1,793,021.6 төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

**ОНГИ ГОЛЫН УРСАЦ
НЭМЭГДҮҮЛЭХ “ОРХОН-
ОНГИ” ЭКО ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

“Усны техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” төслийн

ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний дугаар № БОАЖЯ-ХО-04/2020 тоот гэрээг үндэслэн “Хайдродизайн прожект” ХХК, “Престиж инженеринг” ХХК, “Монхидроконстракшн” ХХК-ууд хамтран “Орхон-Онги” төслийн ТЭЗҮ-г боловсруулсан байна.

Онги гол нь дулааны улирлын шар усны болон хур борооны үерийн горимтой гол юм. Онги голын савд жилдээ орсон хур тунадасны 3-23% гадаргын урсцыг бүрдүүлж үлдсэн дийлэнх хувь нь ууршилт, нэвчилтээр алдагддаг. Онги голын сав газар дахь газрын доорх усны сэргээгддэг нөөцийн хэмжээ 326 сая м³/жил байна гэсэн тооцоо гарч байгаа боловч нийт талбайн 73.4% нь маш бага сэргээгддэг нөөц бүрэлдэх боломжтой (0-5 мм/жил) хэсэгт хамрагдаж байдаг.

Төслийн хүрээнд Орхон, Онги гол дээр нийт 6 байршилд усан цогцолбор байгуулахаар урьдчилан төлөвлөж, холбогдох судалгаа тооцоо хийсний үндсэн дээр хамгийн оновчтой 2 хувилбарыг сонгосон. Үүнд: Орхон-Мөнгөт уул, Онги-Цагаан бургастай хөндлүүр дээр усан цогцолбор байгуулж судалгааг илүү нарийвчлан хийсэн. ТЭЗҮ-ийн үр дүнд дараах усан цогцолборын барилга байгууламжуудыг нийт 1,143.78 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барьж байгуулахаар тооцсон байна.



М.АНХБАЯР: БИ МЭДДЭГСЭН БОЛ ТЭСИЙН ГОЛДОО БААТАР ЦОЛ ОЛГОМООР БАЙНА

Өнгөрч буй зун Усны салбараас хэд хэдэн хүн төрийн дээд шагнал-Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулсан билээ. Тэдний нэг Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны дарга М.Анхбаяртай уулзаж, дараах ярилцлагыг хийлээ.



одоо усны салбарт сав газрын захиргааны даргаар ажиллаад 4 жил болж байна.

Ус хэмээх энэ нандин эрдэнэтэй (энэ салбартай) анх яаж холбогдож байв?

Ус гэдэг энэ нандин эрдэнэтэй эхийн хэвлийд байхаасаа холбогдсон доо. Хүн эхийн хэвлийд байхаасаа л устай холбогдоно шүү дээ. Ус байхгүй бол хэн ч хаана ч амьдрахгүй шүү дээ. Ус байхгүй бол амьдрал байхгүй гэдэг чинь естой үнэн шүү. Усгүй бол ан амьтан, мод ургамал байх уу. Алт амандаа хүлхээд амны цангаа гарч хүн амьд явдаг бол баахан алт нөөцлөөд авчихая л даа. Усгүй хэд хонохыг хар л даа. Ялангуяа төв суурин газрынхан газрын баялагаа ухуулж байгаа аймгууд. 2017 онд намайг Дархан цаазат газрын даргаар 17 жил ажиллахад нэг ажил албан тушаал дээр олон жил боллоо гээд Увс нуур Тэсийн голын сав газрын даргаар сэлгүүлэн ажиллуулах тушаал гаргаж усны салбартаа хувь заяагаа холбосон. Одоо усны агентлагийн дарга Ш.Мягмарын хэлсэнээр Усны ажил бүтвэл улсын ажил бүтнэ гээд гүйж л явна.

Увс нуурын ай сав газар Монголын хамгийн үзэсгэлэнтэй газар орны нэг. Нутгийнхаа хамгийн үзэсгэлэнт газар, нуур усыг нэрлэнэ үү?

Увс нуурын ай сав газар байгалийн бүх бүс бүслүүрийн онцлогийг харуулсан дахин давтагдашгүй хосгүй үзэсгэлэнт байгальтай нэн ховор, ховор ургамал, ан амьтаны өлгий нутаг. Естой нөгөө Цэнхэр тэнгэрийн орон гэдэг чинь энэ дээ. Тэр ч утгаараа намайг Увс нуурын ай савын Дархан цаазат газрын

Та өөрийгөө товч танилцуулна уу ? Усны болон байгаль орчны салбарт хэд дахь жилдээ ажиллаж байна вэ?

Мөнхөө овогтой Анхбаяр миний бие Увс аймгийн Хяргас сумын нутагт 1964 онд эхээс хүй тасарч энэ хорвоод мэндэлжээ. Намайг мэндэлж байхад Австри улсын Инсбург хотноо өвлийн олимп зохион байгуулагдаж Монгол улс анх удаагаа өвлийн олимпд оролцож олимпын их гэр бүлд багтаж байж. Миний төрж өссөн Хяргас нутаг байгалийн хосгүй үзэсгэлэнт болон түүх дурсгалын нандин өвтэй ан амьтан элбэг ус ургамал нь тэгширсэн сайхан нутаг байдаг. Энэ нутгаас их олон алдартан төрсөн. Зууны манлай бөх Хорлоогийн Баянмөнх, Нам төрийн зүтгэлтэн Ж.Батмөнх,

Т.Рагчаа, Ардын цолтонгууд Ц.Өнөрбаян, Ч.Балидар, Ц.Цэвээн нийгэм улс төрийн зүтгэлтэнүүд О.Нямаа, Г.Жамбаа, Д.Пүрэв, О.Шаалуу, Л.Тулга, Д.Намсрай Шинжлэх ухааны доктор профессор 90 гаруй, гавьяат цолтон 50 гаруй, Улсын аварга малчин 30 гаруй төрөн гарчээ. За тэгээд Хүүхдийн байгууллага Байгаль орчны байгууллагад 35 жил ажилласан Анхбаяр гээд явж өгнө дөө. За за тоглосон юм. Миний нэр алдар гэж юу байх вэ. Насаараа хүүхдийн, байгаль орчны гэсэн буянтай хоёр салбарт ажилласандаа бахархдаг даа. Хүүхдийн Анхбаяр Байгаль орчны Анхбаяр Тусгай хамгаалалттай газрын Анхбаяр одоо усны Анхбаяр гэж дуудуулж яваадаа би бахархдаг аа. Миний бие Байгаль орчны салбарт ажиллаад 21 жил

дарга байхад Увс нуурын ай сав ЮНЕСКО-гийн шим мандалын нөөц газрын сүлжээнд хамрагдаж Монголоос анх удаа Дэлхийн өвд бүртгэгдсэн мөн хил дамнасан ТХГН-ийн сүлжээнд хамрагдаж Увс, Айраг, Ачит нуур олон улсын нүүдлийн шувууд дайран өнгөрдөг буюу амьдардаг ач холбогдол бүхий ус намгархаг газрын сүлжээ буюу Рамсарын конвенцид хамрагдсан нутаг.

Энэ бүхэн миний даргаар ажиллаж байх үед бүртгэгдсэнд би сэтгэл хангалуун байдаг. Байгаль эколги нь хосгүй онгон, цэвэр ариунаараа байгаа гэдгийг хэмждэг индикатор амьтан Ирвэс, нутаг орон нь уур амьсгалын өөрчлөлтөнд өртөөгүй онгон дагшнаараа байгааг хэмждэг индикатор амьтан Сибирийн шивэр гүлмэр за тэгээд нэн ховор ан амьтан Аргаль хонь, Янгир ямаа, Хар сүүлт гээд ховор амьтан ургамал бүгд байна даа. Бүгдийг нь тоочиж барахгүйгээс хойш манай нутагт Хандгай, Баавгай хоёр л алга даа. Бусад нь бүгд байна гэж хэлье дээ. Нээрээ Баавгай гэснээс зарим жил хойд хилээр дамжиж хил зөрчиж оросын нутгаас Баавгай орж ирдэг шүү.

Увс аймаг хосгүй тансаг байгальтай учир аялал жуулчлал хөгжих боломжтой. Сүүлийн үед Улаанбаатрынхан 7 сард хотынхоо хаалгыг хаачихаад бүгд манай аймагт ирж Монголдоо хамгийн том Увс, цэнгэг Хяргас, Усан талбайгаараа дээрхи хоёр нуураас ч томд ордог Айраг нуур, Үүрэг, Ачит, Дөрөө, Баяннуурт умбан шумбаж амардаг болсон. За тэгээд Нарийны эхэн хэмээх газарт 5 төрлийн жимс амталж Ямаат Аргалийн аараг Цагаан голд аргаль янгир ирвэс харж мэлмийгээ баясгаж мөнх цастай мөсөн оргилууд Хархираа, Дэглий цагаан, Цагаан шувуут ууланд очиж цас мөсний орныг гайхан алмайрч, Ханхөхийн тайгад 5 төрлийн модон дотор амарч энерги авч тэгээд хэлээд байх юм бол сонины чинь зай багадмаар хол ойрын ирсэн явсан хүмүүст тоочиж барахгүй их бахархал Увс нутагт байна даа.

Ер нь уртаашаа 250 км явахад л та мөнх цастай өндөр уул, ой тайга, тал хээр, дэлхийн бөмбөрцөгийн хамгийн зүүн захад оршдог бөөрөг дэл, алтан элсэн манхан гээд байгалийн бүх бүс бүслүүрийн гайхамшгийг бүгдийг нь харна шүү.

Би тоо баримт хэлье. Увс аймагт нийт 266 гол горхи, 123 нуур тойром, 718 булаг шанд, 45 рашаан, сав газрын хэмжээнд 308 гол горхи, 67 нуур тойром, 648 булаг шанд, 3 баян бүрд, 33 рашаан байна.

Энэ байгууллагыг удирдахдаа та ямар зарчмыг мөрдлөг болгосоор ирэв. Ажил албандаа таны мөрддөг гол зарчим улаан шугам?

Би ямар ч үед шударга байхыг эрхэмлэдэг. Миний улаан шугам ч гэх юм уу даа. Тухайн үеийн нийгэм биднийг ингэж л хүмүүжүүлжээ. Тийм ч учраас би байгаль орчны салбарт 21 жил ажиллахдаа тусгай хамгаалалттай газар нутаг дээр хориотой бүсэд 4 дугуйтай машины мөр гаргуулж хууль бус явдал гаргуулаагүй. Газар нутгаа ухуулаагүй. Жишээ дурдья л даа. Дархан цаазат газрын дарга байхад Хандгайтын зам барьж байсан. Мянганы зам гээд их л сүртэй аян өрнөж байгаагүй юу. Тэгээд Увс нуурын элс авч хэрэглэх гэхэд би өгөөгүй ээ. Ц.Элбэгдоржийн Засгийн газар ажиллаж байсан. Чи улс орны бүтээн байгуулалтыг зогсоолоо. Ажлаас чинь хална



Сав газрын захиргааны хамт олон



энээ тэрээ болсон. Энэ газар чинь Дэлхийн өвд хамрагдсан НҮБ-ын газар, тэндээсээ зөвшөөрөл аваад ир гэсэн.

Зөвшөөрөөгүй юм байлгүй дээ. Чулуу бутлаад элс үйлдвэрлэдэг төхөөрөмж авч ирээд замаа барьчихсан ш дээ.

Мөн “Алтан дорнод монгол” ХХК Үүрэг нуурын баруун талд өрөм тавиад нэг ч хонолгүй хөөгдөөд явсан, Говь эрээн ХХК Түргэн сумын нутагт орчны бүсэд ямар ч бичиг баримтын бүрдэлгүй газар ухааж байгаад хөөгдөөд явсан. Хогоо ч цэвэрлэхгүй торгууль нөхөн төлбөрөө ч төлөхгүй зугатсан. Бид цагдаагийнхантай хамтарч Хяргас нуурын хөвөөнд явж байсныг нь барьж ирж машин тэргийг нь журмын хашаанд хийж байгаад хогийг нь цэвэрлүүлээд торгууль нөхөн төлбөрийг нь төлүүлж байгаад явуулсан шүү. Хууль бус үйл ажиллагаа явуулж байсан тэр хүмүүстэй тухайн сумын удирдлагууд нь гэрээ хийгээд Байгаль хамгаалах төлөвлөгөөг нь батлаад сумандаа 500 мянган төгрөгийн хандив авчихсан байсан гээд бод доо.

Байгалиа хамгаалах гайхамшигтай өв уламжлалтай ард түмэн бол бидний монголчууд. Харамсалтай нь энэ байдал алдагдаж эсрэгээрээ гэмээр хандлага их боллоо. Энэ байдлыг яаж зөв хандлага руу оруулах вэ?

Монголчууд байгалиа хамгаалах гайхамшигтай өв уламжлалттай хүмүүс. Тэр зарчим цусанд нь байдаг учраас харьцангуй ан амьтан агнах явдал гайгүй шүү. Би Дархан цаазат газрын даргын ажил аваад аргаль агнаад 5 жил өнгөрсөн, Ирвэс агнаад 3 жил өнгөрсөн зөрчил илрүүлж арга хэмжээ авч байлаа. Эндээс үзэхэд хулгайгаар мэр сэр агнадаг байж магадгүй.

Ирвэсийг өөр лүү нь дайрахад хамгаалаад буудчихсан гэж хэлдэг. Ирвэс идэш тэжээлийг нь булаахгүй бол хэзээ ч хүн рүү дайрдаггүй л байхгүй юу.

Дэлхийн түүхэнд Ирвэс хүнд халдсан түүх байхгүй. Харин малчид өвөлжөөндөө буугаад Ирвэсийн идэш тэжээл бүхий бэлчээрийг нь эзлэхэд малаас нь ганц нэгийг зооглодог явдал байгаа. Ирвэсэнд малаа идүүлсэн малчид араас нь сүү өргөж залбирч байх хэрэгтэй. Ээ хайрхан хангайн лус савдаг манайх руу уулын эзнээ явуулж өргөл барьцаа авлаа. Бид байгальтай буруу харьцаж байгаа юм байна. Дахиад бид Ирвэсийн нутаг орныг эзэлж хонь малаа бэлчээхгүй гээд. Байгальтай харьцах Монголчуудын харьцаа өөрчлөгдөж байна. Сүүлийн үед залуучууд амарч аялж явахдаа хогоо аваад явдаг болсон. Байгальтай харьцах хандлагыг зөв чиглэлд оруулах арга зам бол ерөөсөө энэ сургуулийн сургалтын хөтөлбөрийг өөрчлөөч дээ. Ардын уламжлал зан заншил, улс орныхоо түүх, соёл амьдрах арга ухаан түлхүү заах хэрэгтэй байна. Аль эртний балар цагийн Грек Ромын түүхээр яах юм. Улирсан баларсан үхсэн хаадуудын нэр цээжлүүлж яах юм. Хэрэгтэй хэрэггүй тоо томъёо толгойнд нь чихэж яах юм. Монголынхоо хаад ноёдын түүхийг заана биз.

Гэр ахуйн хичээл гэж ордог л байсан одоо ч орж л байна. Дээл оёж сурсан нь хэд бол. Ганцхан дээл оёод сурга л даа. Ээж нь дээл оёхыг заагаад сургаад байхад ардын багш байдаггүй ээ. Аягүй бол гэр ахуйн багш өөрөө дээл оёж чаддаггүй байж таарах гээд байна. Гэрийнхээ эвдэрхий сандлыг засдаг болгож сурга л даа. Хоол яаж хийхийг заагаач. Одоо олигтой лавшаа хийдэг хүүхэд байна уу. Газар тариалан эрхлэхийг талх жигнэхийг багаас нь заах хэрэгтэй. Коллежид ороод нас биенд хүрчихсэн хүн чинь юм сурахгүй байна шүү дээ. Багаас нь юм сурах насанд нь зааж сургах естой юм л даа. Би буруу ярьж байж магадгүй. Өөрийн бодол өөртөө л зөв.

Ус болоод байгаль орчинтой холбоотой сэтгэлд тань ойрхон явдаг шүлэг зохиолын мөр бадгаас хэлнэ үү?

-Манай зохиолчдын уул усаа магтсан ерөөсөн шүлэг дуу яруу найраг олон байна даа. Дуу шүлгэнд мөнхрөөгүй гол мөрөн нуур ус гэж байхгүй дээ. Бүгд л магтан дуулах юм. Тэгсэн мөртлөө хайрлаж хямгадахаа мэдэхгүй юм даа. Ариун ус, амин ус, мөнхийн ус, ариун рашаан, Амьд явбал алтан аяганаас ус ууна гээд бишгүй магтана. Магтдаг шигээ хайрлахгүй. За ёс байна нэг шүлгийн мөр хэлье.

Мөнгөн аяга шиг гараас чинь

Туулын уснаас амсахсан

Мөнхийн рашаан уусан юм шиг

Танхил чамтайгаа амьдрахсан. Дорнын яруу найрагч Бэгзийн Явуухулан ингэж шүлэглэж байж. Агуу Агуу гэхээс өөр хэлэх үг алга даа.

Яг өнөөдрийн байдлаар танай байгууллага ямар асуудалд гол анхаарал хандуулж ажиллаж байна вэ?

Одоо бидний гол анхаарал хандуулж байгаа ажил бол энэ хэдэн булаг шанд гол горхио яаж ухуулчихгүй байх вэ. Газрын гүний усаа яаж түлхүү хэрэглэхгүй байгалийн хэрмэл усыг тогтоож хөв байгуулж ашиглах вэ. Гол горхи, булаг шандаа яаж хог буртагт булуулахгүй цэвэр ариун байлгах вэ, усан сан бүхий газрын бүс тогтоож дэглэмийг нь яаж мөрдүүлэх вэ зэрэг олон асуудал анхаарлын төвд байна даа.

Манай байгууллага 2018 оноос хойш усан сан бүхий газрынхаа бүсийг тогтоож уг бүсэд байгаа ашигт малтмалын лицензтэй газруудын давхцалыг тодруулж давхцалтай хэсгийг чөлөөлөх ажлыг хийж байна. Аймгийн хэмжээнд усан сан бүхий газар 1 249 672 га-д онцгой, 1 437 047 га-д энгийн хамгаалалтын бүс тогтоосон. Энэ нь Увс аймгийн газар нутгийн 21,2 хувийг эзэлж байна. За тэгээд усан сан бүхий газар алт олборлох лиценз авсан судалгаа хийгээд үзэхэд 62 ашигт малтмалын тусгай талбайд 92 уст



цэг давхцалтай байснаас бид 16 тусгай зөвшөөрлийг цуцлуулж 2 тусгай зөвшөөрөл эзэмшдэг аж ахуйн нэгж давхцалтай хэсгээ хасуулсанаар 31 гол булаг чөлөөлөгдөөд байна. Одоо 44 тусгай зөвшөөрлийн талбайд 63 гол булаг давхцалтай байна. Одоо усан сан бүхий газрын давхцалтай талбай 7514,54 га, Чөлөөлөгдсөн талбай 2726,29 га, Давхцалтай талбай 4788, 25 га байна даа.

Усаа хадгалах зөв зохистой хэрэглүүлэх тал дээр ямар ажил зохион байгуулвал зохистой вэ?

Хамгийн гол нь эдийн засгийн хөшүүрэг чухал. Хүн амьд явах гол ундаа нандин эрдэнэ усыг хамгийн хямд үнэгүй шахам хэрэглэж байна. Ус ашигласны болон бохирдуулсаны төлбөр ялангуяа бохирдуулагчийн төлбөр маш өндөр байх хэрэгтэй. Хэрэглээний усны төлбөр ялангуяа уул уурхайд ашиглаж байгаа усны төлбөр өндөр байх шаардлагатай. Хүний хэрэгцээт зүйл үйлдвэрлэж байгаа хүнсний салбар, газар тариалангийн салбарт хэрэглэж байгаа усны үнэ хямд байж болно. За тэгээд сургалт сурталчилгаа бусад ажлууд нь байх л даа. Одоо усны гачаалд ороогүй болохоор ойлгож өгөхгүй байна.

Усны үнэ цэнийг мэдрэхгүй байна. Энэ дашрамд усны талаар хэдэн сонирхолтой тоо баримт хэлье. Дэлхийд ойролцоогоор 1,5 тэрбум хүн ундны цэвэр усны хангамж дутагдаж байна. Манайд бороо орсон дараа хонхор газар шавхай тогтдог шүү дээ. Тийм шавхай ууж амьдарч байна. Уснаас шалтгаалж 4 сая хүн нас барж байна. Хүн амьдралын турш 35 тонн ус уудаг. Хүн ус уухгүйгээр 20 хувийн шингэнээ алдвал шууд үхэлд хүрнэ гээд аймшигтай баримт байгаа юм. Даанч ойлгож өгөхгүй юм даа.

Таны ажил үүргээ явуулдаг сав газрынхан бас л онцлог содон сонин сайхан амьдралтай нутаг орон байх аа?

Увс нуур Тэсийн голын дагуу амьдардаг ард түмний нэг онцлог нь өвөлдөө - 50 хэм хүйтэн зундаа +50 хэм халуунд зохицож амьдардаг тул хүн, малгүй чийрэг өлчир, ажилч хичээнгүй тийм ч учраас алдартай бөхчүүд, аргамаг хурдан хөлгүүдийн өлгий нутаг. Тэсийн голын адуу бие даасан үүлдэр болон батламжаа авсан. Бид Швейцарын хөгжлийн агентлаг, Монголын бэлчээр ашиглагчдын холбоотой хамтран “Тэсийн голын монголчууд” төсөл хэрэгжүүлж Увс

нуур, тэс голын дагуу байгалийн үзэсгэлэнтэй газар нутагт аялал жуулчлал хөгжүүлэх энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ард иргэдийг дэмжих “Тэсийн голын монголчууд” нэртэй томоохон фестиваль зохион байгуулж тэр хөдөлмөрч ард түмний аж амьдрал ес заншил, эрхэлж байгаа аж ахуй, хийж бүтээж байгаа бүтээлийг дэлхийд сурталчилж бренд болгохоор зорьж ажиллаж байна.

“Тэс голыг эх оронч гол” ярьж хэлцэх нь бий. Энэ ямар утга учиртай юм бэ?

-Тэсийн гол Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт орших Булнайн нуруунаас эх авч нийт 550 км урсаад ОХУ-аар аялж яваад эргэж Увс нууранд цутгадаг Эх оронч гол. Одоо янз бүрийн байгууллага иргэн монгол улсын баатар цолоор шагнагдаад байна. Би мэддэгсэн бол Тэсийн голдоо Баатар цол олгомоор байна шүү.

Энэ салбарт хүчээ өгсөнөөс хойш таны хийж бүтээсэн хамгийн том ажил үйлс, амжилт бүтээл. Төрөөс таны хөдөлмөрийг хэрхэн үнэлсэн бэ?

Байгаль орчны салбарт 21 жил ажиллахдаа Увс нуурын ай сав газрыг Дэлхийн өвд, 3 нуурыг

рамсарын конвенцид хамруулсан, хил дамнасан хамтарсан Дархан цаазат газар байгуулсан, яам системийн хэмжээнд 7 удаа 1-р байр, 3 удаа 2-р байр, 2 удаа 3-р байр эзэлж 12 удаа түрүүлж үзүүлж шөвгөрсөн гээд бөхөөр бол яасан байна гэж бөх цоллоочоос асуусан чинь Баянмөнх аваргад тун дөхөж байна гэж хэлсэн.

Тэгэхдээ энэ бүх амжилт бүтээлээс хуваалцах эрхтэй манай хамт олон, дэмжлэг үзүүлж байдаг БОАЖЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, санхүүгийн хувьд дэмждэг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Швейцарын хөгжлийн агентлаг гээд олон байгууллага байдаг. Бидэнтэй хамтран ажилладаг дээрхи байгууллага, хамт олонд усны төлөө сэтгэл гаргаж явсаны чинь хариуд хорвоогийн ус уух хувь заяа чинь уртасна гэж ерөөгөөд ажлын амжилт эрүүл энх сайн сайхныг хүсье.

Байгаль орчны салбарт ялангуяа Дархан цаазат газарт ажиллаж байхдаа хийсэн бүх ажил амжилтуудаа багтаасан “Дэлхийд данстай дархлагдсан газар нутаг мину” гэсэн ном хэвлүүлж гаргасан. Түүхийн шарласан хуудсыг сэмхэн баллуурдчихаад хэн нэгэн би хийсэн гэж цээжээ дэлдэж мэднэ.

Усны сав газрын даргаар ажилласанаас хойш 3 жилийн хугацаанд Хяргас сумын нутагт 4,2 тэрбум төгрөгийн далангийн барилгын ажил хийлгэж, 17 булаг хашиж хамгаалж, усан сан бүхий газрын бүс тогтоож ашигт малтмалын лицензтэй газрын давхцал арилгах, горим дэглэм хуулийн хүрээнд мөрдүүлэх ажлыг хийж байна.

Бид жил бүхэн булаг усны тооллого хийж, усан сан бүхий газрын бүсийг тэмдэгжүүлэх, усан сан бүхий газарт хог хаягдал цэвэрлүүлэх, усан сан бүхий газар мод тарих ойжуулах, ус ашиглах дүгнэлт гаргах, усны төлбөр төлөх үндэслэл гаргах, ус бүрэлдэх эх усны нөөц бүхий газрыг улсын болон орон нутгийн хамгаалалтанд хамруулах, усны тоо бүртгэл жил бүр хийх, усны баланс тооцох усны чанар хяналт шинжилгээ хийх зэрэг ажлуудыг сав газрын хэмжээнд болон аймгийн хэмжээнд хийж байна. Ер нь манай бүтэц зохион байгуулалт буруу гэж би үздэг. Сав газрын захиргааг сав газраар нь биш аймгаар нь байгуулах ёстой гэж үздэг. Увс аймгийн усны газар гэж нэрлээд. Зөвхөн манай аймаг гэхэд Увс нуур Тэс гол, Хар нуур Ховд гол, Хяргас нуур Завхан голын сав газарт хамрагдаж Манай сав газар гэхэд Завхан, Хөвсгөл аймгийн

27 сумын нутаг дэвсгэрийг хамарч 54 мянган км кв талбай хариуцдаг. Дарга 4 мэргэжилтэн 1 нягтлан бодогч 1 жолооч нярав нийт 8 хүн хүнд араандаа хийгээд хүндрүүлэгч мостондоо хийчихсэн зүтгэж байна даа.

Төрийн байгуулагад тасралтгүй 35 жил ажилласан миний хөдөлмөрийн амжилтыг үнэлж 2000 онд Хөдөлмөрийн хүндэт медаль, 2011 онд Алтан гадас одон, 2021 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасан.

Олон ч сайхан ажил үйлсийг бүтээж, олон ч сайхан шагналын эзэн болж байжээ. Одоо таны шүтээж явдаг, сүслэн дээдэлдэг зүйлийг тодруулаад энэхүү ярилцлагаа өндөрлөө.

Би их олон шүтээнтэй хүн. Мэдээж төрүүлж өсгөсөн аав ээж, үр хүүхэд хань ижил миний шүтээн. Мөн байгаль дэлхий уул усны лус савдагаа шүтэж, хамгаалж буян хишгийг нь хүртэж явна даа.

Төгсгөлд нь энэхүү сонин уншиж байгаа хүн бүхэнд байгаль орчноо хайрлан хамгаалж ус мөрнөө аривжуулж сэтгэл гаргаваас байгаль дэлхийн хишиг буян та бүхэнд хурж үеийн үед үр үдмаараа эрүүл энх, сайн сайхан явна гэсэн өлзийтэй сайхан ерөөл дэвшүүлье.

Ярилцсан: А.Лхагва



Эх оронч Тэс гол

Хэлтэй, хилтэй, баялагтай бахархалтай энэ Монгол улс алин галавын цагаас ус эрдэнээ эрхэмлэн дээдэлж, ариун дагшинаар нь хадгалж хамгаалахыг удам судар, ураг төрөлдөө захисаар ирсэн төдийгүй хууль цааз, судар бичигтээ тод сайхнаар бичиглэн, ёсчлон сахисаар ирсэн билээ. Шинэ Монгол Улс Үндсэн хуульдаа чухам юу гэж заасан байдгийг он оноор нь товчоолон нийтэллээ.



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

(1924 он)

Гуравдугаар зүйл. Улс төрийн бүх хэргийг ард түмнээс удирдан гүйцэтгэх явдлыг хүндэтгэх ба дээр дурдсан ёсоор улсын үндсийг бататгахад гол болгон явуулбал зохих зүйлүүд нь:

Нэг. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялагууд бол эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь чухал одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно.



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

(1940 он)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Тавдугаар зүйл. Бүх газар шороо ба түүний хөрсөн доорх зүйлүүд, ой мод, ус ба тэдгээрийн баялаг, фабрик, завод, төмөрлөгийн уурхай, алт боловсруулах явдал, төмөр, авто тээврийн зам, усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйнууд нь улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн болно. Эдгээрийг өмчийн хөрөнгө болгож үл болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

УЛСЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

17. Тус улсын байгалийн баялгийг хамгаалах ба ашиглах, газар шороо, ой мод, ус бэлчээр ба түүний баялгийг ашиглах журмыг тогтоох.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД

УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

(1940 он 1994 бүх нийтийн өөрчлөлтийг багтаасан хувилбар)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Тавдугаар зүйл. Бүх газар шороо ба түүний хөрсөн доорх зүйлүүд, ой мод, ус ба тэдгээрийн баялаг, фабрик, завод, төмөрлөгийн уурхай, алт боловсруулах явдал, төмөр, авто тээврийн зам, усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйнууд нь улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн болно. Эдгээрийг өмчийн хөрөнгө болгож үл болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЗАСАГ ТӨРИЙН БАЙГУУЛАМЖ

Аравдугаар зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас түүний засгийн дээд байгууллага ба төрийн удирдах, захирах байгууллагаар төлөөлүүлэн эрхлэх хэсгүүд нь:

С. Тус улсын байгалийн баялгийг хамгаалж, ашиглах явдлыг зохион байгуулах ба газар ус, ой мод, бэлчээр хийгээд тэдгээрийн баялгийг ашиглах журмыг тогтоох.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ӨӨРЧЛӨН НАЙРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдээс тогтоох нь:

БНМАУ-ын Үндсэн хуулийн зарим зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

Тавдугаар зүйл. “Бүх газар, ой мод, ус, тэдгээрийн баялаг, улсын үйлдвэр (фабрика), завод, нийт уурхай, алт боловсруулах явдал зэрэг төмөр замын ба ус, агаарын тээвэр, холбооны хэрэгсэл, банк, сангийн аж ахуй, машинт мал аж ахуйн станц, өвс хадах морин станцууд бол улсын өмч буюу нийтийн хөрөнгө мөн”

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)


УСТАЙ ХОЛБООТОЙ ЗАН ЗАНШЛААС

БИЛЭГДЭЛ:

- Усыг чандмань эрдэнэ гэж билэгдэнэ.
- Гурвын тоогоор усыг билэгдэнэ.
- Гэрийн үүдэн дэхь усан /долгио/ хээ нь сайн сайхан болон ариун далайн мандал дээгүүр нар мандах адил цацран гийсээр орж ирэг, хар муухай санаа /тан/ үүдэнд буй усан далайд унаж саатах болтугай гэсэн утгатай байдаг.

ХОРИО ЦЭЭР:

- Гол ус, рашаан булгийг лусын эзний байр ундаа гэж үздэг учир хөндөхийг аль болохоор цээрлэнэ.
- Рашаан усанд байгаа загас жараахай /ялангуяа могойг/, хорхой шавжийг алж хөнөөхийг цээрлэнэ.
- Рашаан усаар мал сүргээ усалж ундаалахыг цээрлэдэг.
- Рашаан булгийн усанд хиртэй юм угааж бузартуулдаггүй. Юмс угаахдаа түмпэн саванд усаа хийж хол очиж угаана.



- Рашаан булаг, голын ойролцоо морь хардаггүй.
- Голын ус руу сүү цагаа оруулдаггүй.
- Голын уснаас гараараа самарч уудаггүй. Аягаараа хутгаж ууна. /гар юманд хүрч бохирдож байдаг учир усыг бузартахаас айна/.
- Гол мөрний эрэг гуу жалга эвдэхийг хориглоно.
- Голын ойролцоо хүн тавьдаггүй.
- Гол мөрний усанд амьтны сэг хаях, хог урсгах, хиртэй, цустай гараа угаах цээртэй.
- Булгийн тархин дээр буудаггүй.
- Булаг шандын эхийг хөндөх, хамаа бусаар задгайлахыг хориглоно. Усны үер, аюул болно. Эсвэл ус алга болно
- Зун нар буцахаас өмнө урсгал усыг түүхий ус гэх учир биеэ угаадаггүй.

- Хаврын урсгал усыг түүхий гэх учир биеэ угаадаггүй.

- Зуны шар багваахай цэцэг цэцэглэж гүйцсэний дараа усанд орно.



- Тогтмол усанд биеэ, хувцсаа угаахыг цээрлэнэ.
- Усанд морь харах, хүндрэх цээртэй.
- Ус руу чулуу шиддэггүй. Лус хилэгнэнэ гэж үзнэ.
- Сүүн дээр ус хийдэггүй. /Сүүн дээр ус хийх тусгай дом бий/.
- Худаг, булгийн уснаас асгаж цутгахгүй авна.
- Усаар тоглодоггүй.
- Худаг усан дээр хоосон сав суулга дээш харуулж тавьж саатах, удаахыг цээрлэнэ. Саваа хөмөрч тавина эсвэл таглана. Эс гүйцэтгэвээс ус татарна.
- Ховооны орхиулыг чирдэггүй, худаг бузартана.
- Худгийн амсар дээр ус руу сандайлж суудаггүй. Хормой хот, бөгсөөрөө ус бузарлана.
- Морь малаа услаад онгоцоо хоосон орхидоггүй. Ядаж богшрог, шаазгай ус ууг. Дараагийнх нь ирсэн мал ус ууг.
- Нуур цөөрөмд ам гардаггүй. Энэ муу шалбааг юухан байхав гэхчилэн ам алдваас үйж үхнэ, амиа алдана.
- Догшин газрын ус голын нэр юм уу зарим худгийн /голцуу зүүн хойшоо харсан амны/ нэрийг цээрлэнэ
- Усны хүйс, усны цоожтой газрыг хөнддөггүй. Ус нь гоожсоор дуусдаг, дундардаг.

ҮЙЛДЭХ ЗАН ҮЙЛ:

- Бурханыхаа өмнө усан тахил хэмээх тахил тавьж хүндэтгэл үзүүлдэг.
- Усны овоог тахигдаа усныхаа өмнө талд овоогоо босгоод түүнээ нар буруу гурав тойрч овооныхоо өмнөөс биш ус руугаа чигтэй харж залбирна.
- Усыг мөнгө, архиар тахиж рашаанаар ариулна.
- Усыг мөнгө, архиар тахиж рашаанаар ариулна. Сүү, махны зүйл оруулахгүй.
- Рашааны усыг ихэд хүндэтгэн овоо босгож, тэмдэг тавиад хадаг далны ясыг зүүж хүндлэн тахина.